



**Гадаад Хэлний Сургуулийн
Оюутны Зөвлөлийн 12-р сарын Ажлын Тайлан**

Тайланг хянасан:

ШУТИС ГХС-ийн Сургалт, Чанарын Албаны Дарга:



А. Болормаа

Тайланг боловсруулсан:

ГХС-ийн Оюутны Зөвлөлийн Нарийн Бичиг:

Б. Соёлмаа

Б. Соёлмаа

12 сард зохион байгуулсан үйл ажиллагаа

1. Монголын Шатрын Холбоотой хамтран ШУТИС-ийн багш, ажилчин, оюутан, сурагч, төгсөгчдийн дунд шатрын аварга шалгаруулах нээлттэй тэмцээн зохион байгуулсан.

1. Шатрын нээлттэй тэмцээн

Монголын Шатрын Холбоотой хамтран ШУТИС-ийн багш, ажилчин, оюутан, сурагч, төгсөгчдийн дунд шатрын аварга шалгаруулах нээлттэй тэмцээн зохион байгуулсан.

- Үйл ажиллагааны зорилго: Шатрын спортыг ШУТИС-ийн хүрээнд түгээн дэлгэрүүлэх, багш оюутнуудын хоорондын харилцаа болон төгсөгчдийн эргэх холбоог сайжруулахад оршино.
- Хэзээ, хаана болсон: 12-р сарын 13-14нд, Төв номын сан 3 давхарт
- Хамрагдалт: ШУТИС-ийн бүх багш, ажилчин, оюутан, төгсөгч, харьяа ахлах сургуулийн сурагчид
- Үр дүн: Тэмцээний онцлог давуу тал нь Монголын Шатрын Холбооны дотоод чансаа тооцогдсон, мөн 4 сая төгрөгийн шагналын сантай, Улсын хэмжээний зохион байгуулалттай, Олон улсын шатрын холбооны дүрмийг мөрдөн явуулсан, өрсөлдөөн өндөртэй, чанартай, ач холбогдол бүхий тэмцээн болж зохион байгуулагдсанд оршиж байлаа.

Тэмцээнд нийт 83 тамирчин оролцсоноос:

Олон Улсын цолтой 21 тамирчин,

МШХ-ны дотоод чансаатай 50 тамирчин,

Шинээр чансаа авах 10 гаруй тамирчин өрсөлдөж, өндөр түвшний, үр дүнтэй тэмцээн боллоо.

Тэмцээний Ерөнхий шүүгчээр Л. Чойжилмаа багштай, ТТО Хятад хэл–1 дамжааны оюутан, Монголын Шатрын Холбооны Шүүгчдийн зөвлөлийн гишүүн, 2025 оны Алтан Бэрс номинацын шилдэг шүүгч, Олон Улсын Шүүгч С. Ган-Эрдэнэ амжилттай ажиллалаа.

Зохион байгуулагчаар:

ГХС-ийн Оюутны Зөвлөлийн гишүүн :ТТО Хятад хэл–3 дамжааны оюутан Б. Соёлмаа,

ТТО Хятад хэл–3 дамжааны оюутан Д. Дэлгэрцэцэг,

ТТО Хятад хэл–4 дамжааны оюутан Ц. Амгалангоо,

ТТО Англи хэл–1 дамжааны оюутан Т. Номинтуяа нар идэвх, зүтгэлтэйгээр ажиллалаа.

Эрэгтэй төрөлд:

- **I байр** – МХТС-ийн оюутан, Спортын мастер **Э. Эрхэмбаяр**
- **II байр** – МХТС-ийн оюутан, ҮШБ, Олон улсын мастер **С. Ган-Эрдэнэ**
- **III байр** – ШУТИС-ийн ахлах сургуулийн төгсөгч, Олон улсын шатрын холбооны мастер **Ц. Тэнгис**

Нийт ШУТИС-ийн хэмжээнд 7 тамирчин МШХ-ны Дотоод Чансаатай болсон

[illegible]

Зураг 1.1 Тэмцээний удирдамж



Зураг 1.2 Тэмцээний шагнал гардуулах үеэр



Зураг 1.3 Тэмцээний зохион байгуулагчид



Зураг 1.4 Тэмцээний үеэр